

ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Э.ОДБАЯРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт								
Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
					3	4		
Зорилт 1. "Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах"								
1.	Бараа, тээврийн хэрэгсэл, чингэлэгийн хяналтыг сайжруулах.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Эхний хагас жилд: -Бараа, тээврийн хэрэгслийн гаалийн хяналтад бүрэн хамруулсан байна. -Гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлсэн байна. Сүүлийн хагас жилд: -Бараа, тээврийн хэрэгслийн гаалийн хяналтад бүрэн хамруулсан байна. -Түр хугацаагаар оруулсан тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг сайжруулсан байна. -Гаалийн газар, хороодод чиглэл хүргүүлсэн байна.	1.Улсын хилээр бараа, зорчигч тээвэрлэн, эсхүл хоосон нэвтрүүлэх тээврийн хэрэгслийг гаалийн байгууллага бүртгэн, гаалийн хяналтад авч, гаалийн шалгалт хийж байна. Хилээр түр хугацаагаар нэвтрүүлсэн тээврийн хэрэгслийн хяналтыг сайжруулах зорилгоор гаалийн газар, хороодод 2024.07.05-ны өдрийн 02-1/2761 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлж, хяналт тавьж ажилласны үр дүнд 2023 онд хилээр хугацаандаа буцаж нэвтрээгүй 11275 тээврийн хэрэгсэл байсан бол 2024 онд дээрх тээврийн хэрэгслийн тоо 8608 болж 23.6 % буурсан байна. 2.Гаалийн хяналт, шалгалтыг сайжруулж, оновчтой зохион байгуулж, гаалийн хууль тогтоомжийн зөрчил илрүүлэлтийг нэмэгдүүлж, улсын хилээр нэвтрэх бараа, тээврийн хэрэгслийг хяналтад бүрэн хамруулах зорилгоор гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авах тухай АТГ-аас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 06/7013 дугаартай албан бичгийн хавсралтаар ирүүлсэн 49 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийг үндэслэн гаалийн газар, хороодод хяналтаа сайжруулах тухай чиглэлийг 02-1/1637 дугаартай 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хүргүүлсэн. Дээрх чиглэлийн дагуу гаалийн газар, хороодын дарга нараас ирүүлсэн хариуг хүлээн авч хянаж, танилцаад 2024.05.16-ны өдрийн 02-1/1957 дугаартай албан бичгээр АТГ-д хариу хүргүүлсэн. Хүрсэн түвшин:		01.02 12.10	

					1.Улсын хилээр бараа, зорчигч тээвэрлэн, эсхүл хоосон нэвтрээд хугацаандаа хаагдаагүй тээврийн хэрэгслийн тоо 23.6 % буурсан байна. 2.АТГ-аас 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 06/7013 дугаартай албан бичгийн хавсралтаар ирүүлсэн 49 дугаартай мөрдөгчийн мэдэгдлийг үндэслэн гаалийн газар, хороодод хяналтаа сайжруулах тухай чиглэлийг 02-1/1637 дугаартай 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр хүргүүлсэн. 3.Хилээр нэвтрүүлэх барааг гаалийн хяналтад бүрэн хамруулахтай холбогдуулан гаалийн газар, хороодын дарга нарт: -2024.01.31-ний өдрийн 02-1/431; -2024.02.02-ны өдрийн 02-1/462; -2024.06.13-ны өдрийн 02-1/2490; -2024.07.05-ны өдрийн 02-1/2768 дугаартай албан бичгүүдээр чиглэл хүргүүлж, хяналт тавьж ажилласан.		
2.	Гаалийн хяналтын тоног төхөөрөмж, эрэлч нохойг гаалийн хяналтад үр дүнтэй ашигласан байдал.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Эхний хагас жилд: -Боомтын шинэчлэлтэй уялдуулан шаардлагатай хяналтын тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, саналаа СХОГ-т хүргүүлсэн байна. -Хяналтын тоног төхөөрөмж, эрэлч нохойг хяналтад үр дүнтэй ашиглах чиглэлийг гаалийн газар, хороодод хүргүүлсэн байна. Сүүлийн хагас жилд: -Гаалийн газар, хороод дахь хяналтын тоног төхөөрөмжийн ашиглалтыг тодорхой хугацаанд хянах арга судалсан байна.	1.Боомтын шинэчлэлтэй уялдуулан шаардлагатай хяналтын тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, саналаа СХОГ-т 2024.01, 04, 05, 06, 11 дүгээр саруудад 35, 156, 216, 248 дотоод зурвасаар: -9 хилийн боомтод 2024 онд худалдан авах шаардлагатай 5 төрлийн 24 ш тоног төхөөрөмж, -Хавирга, Баянхошуу, боомтод 40м*200тн, Цагааннуур боомтод 14м*150тн пүү; -Бичигт боомтод шаардлагатай 7 төрлийн 20 тоног төхөөрөмж, RFID суурилуулахад шаардагдах 20 иж бүрдлийн жагсаалтыг хүргүүлсэн. -Замын-Үүд боомт дахь 2203 м2 талбайтай байрыг нарийвчилсан шалгалтын зориулалтаар ашиглахаар төлөвлөсөнтэй холбогдуулан шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа, шаардлагатай энгэрийн камер, автопүү, рентгены тоог хүргүүлсэн. -харьяа гаалийн газар хороодын хяналт, шалгалтад ашиглах 7,325.2 төгрөгийн үнийн дүнтэй 10 төрлийн тоног төхөөрөмжийг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар тус тус хүргүүлсэн. 2.Гаалийн хяналт шалгалтад хяналтын тоног төхөөрөмж, эрэлч нохой ашиглаж үр дүнг	01.02 12.10	

					нэмэгдүүлэх чиглэлийг 2024 оны 1, 2, 4, 7, 12 дугаар саруудад 02-1/421, 462, 1542, 1637, 2728, 2768, 5009 дугаартай албан бичгээр хүргүүлэн хяналт тавьж ажилласан. ГУБ нарын рентгены дүрс зургийг таньж унших ур чадварыг дээшлүүлэх зорилгоор ИНУТ-ийн НСТ-д "Тоног төхөөрөмж ашиглан үзлэг шалгалт хийх 16 цагийн хөтөлбөрт 90, ОХУ-ын ИСБА компани, ОХУ-ын Санкт-Петербург дахь Электотехникийн дээд сургуулийн багш нарын сургалтад 14 буюу нийт 104 албан хаагчдыг хамруулсан. ЗҮГГ-ын албан хаагч нарт тоон гарын үсгийн токен төхөөрөмжийг ашиглуулж эхэлсэнтэй холбогдуулан тус газарт хуваарилагдсан зөөврийн таблетыг ашиглах боломжгүй болсон тул УБГГ-т хуваарилсан 1 зөөврийн таблет /Zebra L 10 android rugged/-ыг МТГ-т хүргүүлж, асуудлыг яаралтай шийдвэрлүүлсэн. ГЕГ-ын дэргэдэх МТГ-т 2024.07.02-ны өдрийн 277 дугаартай дотоод зурвасаар санал хүргүүлэн, CAIS->Тээвэр->хэсэгт тээврийн хэрэгслийг рентгенээр шалгасан эсэх мэдээллийг оруулж, дүрс зургийг хавсаргах нэмэлт, өөрчлөлт оруулсан. ОХУ-ын ИСБ-А компанийн мэргэжилтэнүүдтэй хамтран ажиллаж, чингэлэг, ачааны тээврийн хэрэгсэл шалгах зориулалттай тус компанийн ИСБА Булган рентгены програмд нэмэлт, хөгжүүлэлт хийлгэх санал хүргүүлэн, зорчигчийн автобус, суудлын тээврийн хэрэгсэл, ачааны тээврийн хэрэгслийг жолоочийн хамт унших өөрчлөлтийг 2024 оны 8 дугаар сард хийлгэсэн. CAIS->Манифестын програмын дагалдах бичиг баримт хэсэгт ачаатай тээврийн хэрэгслийн дүрс зургийг файлаар хавсаргаж илгээдэг нэмэлт, өөрчлөлтийг оруулж, бүрдүүлэлтийн бүх шатанд рентген зургийг татаж харах боломжтой болгосноор рентген зургийн ашиглалтыг нэмэгдүүлсэн. Гаалийн газар, хороод рентгены ашиглалтын мэдээг өдөр бүр CERP-ийн Хилийн хөдөлгөөний мэдээ хэсэгт оруулах нэмэлт, өөрчлөлт хийлгэж, оруулсаны үр дүнд рентгены ашиглалтад өдөр тутам хяналт тавьж ажиллаж байна. Харьяа гаалийн 13 газар, хороодод 2024 оны жилийн эцсийн байдлаар 33 эрэлч нохойг гаалийн хяналт, шалгалтад ашиглаж 38 зөрчил		
--	--	--	--	--	---	--	--

					илрүүлсэн. Албаны эрэлч нохойг гаалийн хяналтад ашиглаж 2023 онд 20 зөрчил илрүүлж байсан бол 2024 онд 38 зөрчил илрүүлсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 90% өссөн үзүүлэлттэй байна. ХҮРСЭН ҮР ДҮН: 1.Боомтын шинэчлэлтэй уялдуулан шаардлагатай хяналтын тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж, саналаа СХОГ-т 5 удаа, мөн харьяа гаалийн газар хороодын хяналт, шалгалтад ашиглах 7,325.2 төгрөгийн үнийн дүнтэй 10 төрлийн тоног төхөөрөмжийг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулинд тусгуулахаар тус тус хүргүүлсэн. 2. 2024 оны жилийн эцсийн байдлаар харьяа гаалийн 13 газар, хороодод 33 эрэлч нохойг гаалийн хяналт, шалгалтад ашиглаж 38 зөрчил илрүүлсэн. Албаны эрэлч нохойг гаалийн хяналтад ашиглаж 2023 онд 20 зөрчил илрүүлж байсан бол 2024 онд 38 зөрчил илрүүлсэнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 90% өссөн үзүүлэлттэй байна. 3.Гаалийн газар, хороод рентгены ашиглалтын мэдээг өдөр бүр CERP-ийн Хилийн хөдөлгөөний мэдээ хэсэгт оруулах нэмэлт, өөрчлөлт хийлгэж, оруулсаны үр дүнд рентгены ашиглалтад өдөр тутам хяналт тавьж ажиладаг болсон; 4.CAIS->Манифестын програмын дагалдах бичиг баримт хэсэгт ачаатай тээврийн хэрэгслийн дүрс зургийг файлаар хавсаргаж илгээдэг нэмэлт, өөрчлөлтийг оруулж, бүрдүүлэлтийн бүх шатанд рентген зургийг татаж харах боломжтой болгосноор рентген зургийн ашиглалтыг нэмэгдүүлсэн. 5.Гаалийн хяналтад энгэрийн камерын ашиглалтыг нэмэгдүүлж, 7 хоног бүр CERP-д оруулсан бичлэг хүлээлцсэн тэмдэглэлийг хянадаг болсон.		
3.	IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдын	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Эхний хагас жилд: ОУАТХ-ны программ хангамжийн багтай цахимаар холбогдож 2 талын хугацаа нь дууссан эрхийг нээлгэсэн байна.	Олон Улсын автотээврийн холбооны програм хангамжийн багтай Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд ТИР-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг уялдуулж, холбох ажлыг 2021 оны 9 дүгээр сараас эхлэн хэрэгжүүлсэн. IRU-ийн зөвлөх Вахтанг Зарандиятай 2024.05.22-ны өдөр харилцан санал	01.02 12.10	

	нэгдсэн холбоо (НАРТАМ) – той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох			Сүүлийн хагас жилд: IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдийн нэгдсэн холбоо (НАРТАМ) -той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох программыг туршиж, нэвтрүүлсэн байна.	солилцож, тохиролцсоны дагуу 2024.10.24-ний өдрөөс эхлэн IRU-тай TIR-EPD-ийн 6 элементийг туршиж, дараа нь CAIS-т нарийн үйлдлүүдийг хийсэн. ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзориг ахлуулсан ажлын хэсгийн хамт 2024.11.10 - 2024.11.15-ны өдрүүдэд Замын-Үүд боомтод томилолтоор ажиллаж CAIS-т TIR-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбох туршилтыг хийж, амжилттай нэвтрүүлсэн. Дээрх ажилтай холбоотойгоор МТГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Ганзориг 2024.11.11-ний өдөр CAIS-т TIR-ын урьдчилсан цахим мэдүүлгийн систем TIR-EPD-ийг бүртгэх сургалтыг ЗҮГГ-т зохион байгуулж, ЗҮГГ-ын 15 албан хаагчийг танхимаар, УБГГ, СЭГГ, БӨГГ, ХОГГ, ДАГГ-ын 98 албан хаагчийг цахимаар оролцуулсан. ГЕГ-ын дарга Р.Отгонжаргал Олон улсын автотээврийн холбооны TIR болон дамжин өнгөрөх тээврийн хэлтсийн ахлах зөвлөх Вахтанг Зарандиятай 2024.11.18-ны өдөр ГЕГ-ын 1 дүгээр давхарын хурлын танхимд хийсэн уулзалтад оролцож, CAIS системд TIR-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн ажлын явцыг дүгнэсэн. Цаашид Замын-Үүдээс бусад боомтоор TIR карней бүхий бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн мэдээг CAIS-т хүлээн авах хугацааг тодруулах, ойлголтын зөрүүг арилгах зорилгоор ГЕГ-ын ХБГ, ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын албан хаагч нар IRU-ын програм хангамжийн багийнхантай хамтарч ажиллаж байна. ХҮРСЭН ҮР ДҮН: 1.Монгол Улсын гаалийн байгууллагын CAIS системд 2024.11.24-ний өдөр TIR-ын гаалийн урьдчилсан цахим мэдүүлгийн систем (TIR-EPD)-ийг холбож, нэвтрүүлсэн. 2.CAIS-т TIR-ын урьдчилсан цахим мэдүүлгийн систем TIR-EPD-ийг бүртгэх сургалтыг 2024.11.11-ний өдөр ГЕГ-ын дэргэдэх МТГ-ын албан хаагч нартай хамтран ЗҮГГ-т зохион байгуулж, ЗҮГГ-ын		
--	---	--	--	---	--	--	--

					15 албан хаагчийг танхимаар, УБГГ, СЭГГ, БӨГГ, ХОГГ, ДАГГ-ын 98 албан хаагчийг цахимаар оролцуулсан.		
					4.IRU-ийн ТИР болон транзит хариуцсан ахлах зөвлөх Вахтанг Зарандиятай хамтран TIR-EPD холболтын гүйцэтгэлийн үнэлгээ, CAIS дахь ТИР карней статусыг шалгах, EGIS шалгалтыг хэрхэн хийсэн тухай, EPD028/EPD016 мессежийг автоматжуулахтай холбоотой техникийн асуудлуудыг хамтран хянасан.		
4	Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Эхний хагас жилд: Бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг хариуцсан нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна. Сүүлийн хагас жилд: Бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлт болон хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлд зохион байгуулсан арга хэмжээний биелэлтийг хариуцсан нэгжид хугацаанд нь хүргүүлсэн байна.	Дараах бодлогын бичиг баримт, эрх зүйн актын биелэлтийг гаргаж, ГЕГ-ын ХХ-т сар бүр тогтмол хүргүүлсэн: ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ: -2022.10.05-ны 362 дугаар тогтоолын 3; -2022.11.23-ны 412 дугаар тогтоолын 2; -2023.04.19-ний 146 дугаар тогтоолын 2; ЗАСГИЙН ГАЗРЫН ТЭМДЭГЛЭЛ: -2023.10.04-ний 40-р тэмдэглэлийн 1; -2024.05.15-ны 19-р тэмдэглэлийн 1; ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР: -2022.12.16-ны 10-р даалгаврын 3; -2024.01.12-ны 01-р даалгаврын 1.7.	01.02 12.10	
5	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр		Эхний хагас жилд: Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна. Сүүлийн хагас жилд:	Удирдлагаас өгсөн үүргийн дагуу ҮАБГ-т хүргүүлэх ТИР горимын тээвэрлэлтэд гаалийн байгууллагаас тавьж байгаа хяналтын талаарх танилцуулгын тоон мэдээллийг бэлтгэж, 2024.06.14-ний өдөр дэд даргад viber-аар хүргүүлсэн.	01.02 12.10	

				Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь гүйцэтгэсэн байна.			
6	Томилолтоор ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Замын-Үүд боомтод томилолтоор ажиллах	ГЕГ-ын дэд даргын 2024.06.18-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Замын-Үүд боомтын ачаа тээврийн ачааллыг бууруулах, төвлөрлийг сааруулж, гаалийн хяналтыг оновчтой зохион байгуулах төлөвлөгөө, 2024 оны улсын төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх шуурхай ажлын төлөвлөгөөний биелэлттэй газар дээр нь танилцахаар 2024.06.19-2024.06.25-ны өдрүүдэд Замын-Үүд боомтод томилолтоор ажилласан.	06.19 06.25	100
7	Томилолтоор ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын дэд даргын 2024.07.30-ны өдөр баталсан удирдамжийн дагуу томилолтоор ажиллах	ГЕГ-ын дэд даргын 2024.07.30-ны өдөр баталсан удирдамжийн дагуу ГУБ Э.Одбаяр Булган, Боршоо боомтод 2024.08.02-12-ны өдрүүдэд ажиллаж, шинээр суурилуулсан Булган-ИСБА 008 шаардлага хангасан эсэхийг ГУАБ Ц.Цэвэндарь, СХОГ, БХ, ШУТ-ийн албан хаагч нарын хамт шалгасан.	08.02 08.12	100
8	Томилолтоор ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Алтанбулаг боомтод томилолтоор ажиллах	ГЕГ-ын даргын 2024.10.08-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Алтанбулаг боомт дахь ачааны, суудлын тээврийн хэрэгсэл шалгах рентгены засварыг гүйцэтгэх гэрээ байгуулсан Масс теч ХХК-ийн гүйцэтгэлийг шалгахаар тус боомтод 2024.10.09-11-ний өдрүүдэд СХОГ, БХ-ийн албан хаагч нарын хамт томилолтоор ажилласан.	10.09 10.11	100
9	Томилолтоор ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын даргын 2024.11.25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу томилолтоор ажиллах	ГЕГ-ын даргын 2024.11.07-ны өдөр баталсан удирдамжийн дагуу 2024.11.10-2024.11.15-ны өдрүүдэд Замын-Үүд боомтод CAIS-т TIR -EPD-г холбож, нэвтрүүлэх, рентгены дүрс зургийг CAIS-т холбох, ХУН төслийн хүрээнд ХХЕГ-тай тээврийн хэрэгслийн мэдээлэл солилцох ажлыг туршиж, нэвтрүүлэхээр томилолтоор ажилласан.	11.10 11.15	100
10	Томилолтоор ажиллах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын даргын 2024.11.25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу томилолтоор ажиллах	ГЕГ-ын даргын 2024.11.25-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Гашуунсухайт боомтод суурилуулсан рентгений угсралт, суурилуулалт, тохируулга, ажиллагаа зэргийг шалгаж, хүлээн авах ажлаар БХ, СХОГ, ОНХА-ны албан хаагч нарын хамт 2024.11.27-2024.11.30-ны өдрүүдэд томилолтоор ажилласан.	11.27 11.30	100

11	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	-Ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, томилолт, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох, томилолтоор ажиллах, ээлжийн амралт, чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулан, илгээнэ.	2024 онд ажлын өдрийн өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж: -томилолтоор ажиллах 7 удаа; -уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцох 5 удаа; -ээлжийн амралтын 1 удаа; -бусад 12 буюу нийт 25 хүсэлтийг тус тус CERP-д тухай бүр оруулан, илгээж, хянуулсан. 2024 онд 1496 минут илүү цаг ажилласан бичлэг CERP-д байна.	01.02 12.10	100
----	--------------------	------------------------	---	---	---	----------------	-----

Хоёр: Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	Уулзалтад оролцох	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	УБТЗ-ын гаалийн хэлтэсээс зохион байгуулсан уулзалтад оролцох	УБТЗ-ын гаалийн хэлтэсээс 2024.02.06-ны өдрийн 10:00-12:00 цагт зохион байгуулсан төмөр замын боомтоор нэвтрэх барааны дагалдах бичиг баримтыг цахимаар солилцох ажлыг эхлүүлэх, эхний ээлжинд экспортын гаалийн мэдүүлэгт RDF-ээр хавсаргасан бичиг баримтыг гаалийн байгууллагаас УБТЗ ХНН-т цахимаар хүргүүлэх асуудлаар ГУАБ Ц.Цэвээндарийн хамт оролцсон.	01.26 01.26	100
2	Цахим уулзалтад оролцох	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын цахим уулзалтад оролцох	НҮБ-ын Хар тамхи, гэмт хэргийн албанаас /UNODC/ хэрэгжүүлдэг чингэлэг хяналтын хөтөлбөртэй холбоотой асуудлаар Tomas Dixon-той 2024.04.09-ний өдрийн 16:00 цагт ГЕГ-ын 1 дүгээр давхарын хурлын танхимд 15:30-17:00 цагт цахимаар зохион байгуулагдсан уулзалтад ХБГ-ын ГУАБ Б.Болормаа ГХАХ-ийн ГУАБ Х.Мөнхзул, ЗТГ-ын ГУБ Бат-Эрдэнэ нарын хамт оролцсон.	04.09 04.09	100
3	ЧХОУНБГГ-ын үйл ажиллагааг танилцуулах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	НҮБ-ын чингэлэг хяналтын хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэх судалгааны багийн ажилтан Tomas Dixon,	ГЕГ-ын даргын 2024.04.10-ны өдөр баталсан хөтөлбөрийн дагуу НҮБ-ын чингэлэг хяналтын хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэх судалгааны багийн ажилтан Tomas Dixon, Hugo Bartoly нарт ГУАБ Ц.Цэвээндарийн хамт ЧХОУНБГГ дахь гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааг 2024.04.12-ны өдөр танилцуулсан.	04.12 04.12	100

				Hugo Bartoly нартай ажиллах			
4	Уулзалт зохион байгуулах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ИСБА компанийн ажилтануудтай хийх уулзалтад оролцох	Булган боомтод суурилуулах ИСБА рентгены байршил боомтын барилгатай давхацсан асуудлыг шийдвэрлэх, шинээр 2024 онд нийлүүлэх 2 рентгеныг нийлүүлэх боомтыг тохирох асуудлаар ИСБА компанийн ажилтануудтай 2024.04.11-ний өдрийн 09:00 цагт ХБГ, СХОГ, БХХ-ийн албан хаагч нар уулзалтыг зохион байгуулж оролцсон.	04.11 04.11	100
5	Хуралд оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Silk way rally зохион байгуулах ажлын хэсгээс зохион байгуулах хуралд оролцох	Silk way rally зохион байгуулах ажлын хэсгээс 2024.05.07-ны өдөр зохион байгуулсан хуралд оролцсон.	05.07 05.07	100
6	Уулзалтад оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын даргын 2024.05.13-ны өдрийн А/247 тушаалаар уулзалтад оролцох.	ГЕГ-ын даргын 2024.05.13-ны өдрийн А-247 дугаартай тушаалаар БНХАУ-ын Хоргос боомтод IRU-аас 2024.05.20-2024.05.23-нд зохион байгуулах Төв Азийн орнуудын гаалийн байгууллагуудын ТИР горимын тээвэрлэлтэд тавьж байгаа гаалийн хяналт, шалгалттай холбоотой уулзалтад оролцож, Монголын гаалийн байгууллагын үйл ажиллагааг танилцуулсан. Уулзалтын тайланг 2024.05.30-ны өдөр удирдлагад танилцуулж, ГХАХ-д хүргүүлсэн.	05.20 05.25	100
7	Уулзалт хэлэлцүүлэгт оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ЗТХЯ, ИНЕГ-аас зохион байгуулах уулзалтад оролцох	ЗТХЯ-аас ирүүлсэн 2024.06.11-ний өдрийн 03/2597 дугаартай албан бичгийн дагуу жуулчдын ачаалал нэмэгдэх үеэр нисэх буудлын үйл ажиллагааг дараалал үүсгэхгүйгээр зохион байгуулахтай холбоотойгоор ЧХОУНБ-д ИНЕГ-аас зохион байгуулах хамтарсан уулзалт хэлэлцүүлэгт оролцсон.	06.18 06.18	100
8	Ажлын хэсэгт ажиллах.	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын даргын 2023.11.02-ны өдрийн А/518 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах	ГЕГ-ын даргын 2023.11.02-ны өдрийн А/518 дугаартай тушаалаар СБ, АБ боомтод телехяналтын систем нийлүүлэх Б-15 дугаар гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах ажлын хэсэгт ажилласан.	01.02 06.05	100

9	Ажлын хэсэгт ажиллах.	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын даргын 2023.11.03-ны өдрийн А/519 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах	ГЕГ-ын даргын 2023.11.03-ны өдрийн А/519 дугаартай тушаалаар Боршоо боомтод телехяналтын систем нийлүүлэх Б-15 дугаар гэрээний хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих, туршиж шалгах, хүлээн авах ажлын хэсэгт ажилласан.	01.02 06.05	100
10	Уулзалтад оролцох	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	КАРЕК-ийн бүс дэх улс орнуудын чингэлэг тээвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор судалгаа төслийн багийн удирдагчтай хийх уулзалтад оролцох.	АХБ болон Төв Азийн Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны хүрээлэнгээс "ТА 6694 REG" техникийн туслалцааны хөтөлбөрийн хүрээнд КАРЕК-ийн бүс дэх улс орнуудын чингэлэг тээвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор судалгаа хийж байгаатай холбоотойгоор тус төслийн багийн удирдагч Макс Ии тэргүүтэй төлөөлөгч нартай 2024.09.12-ны өдөр ХБГ-ын дарга Б.Даваасүрэн, ГУАБ Б.Болормаа нарын хамт уулзалт зохион байгууллаа.	09.12 09.12	100
11	ГГХ-ын алба хаагч нарт сургалт	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын даргын 2024.11.07-ны өдөр баталсан удирдамжийн дагуу томилолтоор ажиллах.	CAIS-т TIR-ын урьдчилсан цахим мэдүүлгийн систем TIR-EPD-ийг бүртгэх сургалтыг ГЕГ-ын дэргэдэх МТГ-тай хамтран ЗҮГГ-т зохион байгуулж, ЗҮГГ-ын 15 албан хаагчийг танхимаар, УБГГ, СЭГГ, БӨГГ, ХОГГ, ДАГГ-ын 98 албан хаагчийг цахимаар оролцуулсан.	11.10 11.15	100
12	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт хичээл заах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын СТ-өөс гаргасан хуваарийн дагуу гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэнүүдэд хичээл заах	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний анхан шатны сургалтад хамрагдаж буй 100 ажилтанд 2024.02.01-ний өдөр ТИР горим, түр тээврийн хэрэгслийн хяналттай холбоотой сэдвээр хичээл заасан.	05.17 06.05	100
13	Гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт хичээл заах	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	ГЕГ-ын СТ-өөс гаргасан хуваарийн дагуу гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт хичээл заах	Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад хамрагдсан 85 оролцогч нарт 2024.02.16-ны өдөр ТИР горим, түр тээврийн хэрэгслийн хяналттай холбоотой сэдвээр хичээл заасан.	02.16 02.16	100

Гурав. Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт		Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
		Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт		
"ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД					

1	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	ОУВС-ийн Санхүүгийн асуудал эрхэлсэн Томас Хансены "Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааны дэвшилтэд арга техник" сэдвээр 2024.04.08-10-ны өдрүүдэд зохион байгуулагдсан семинарт оролцсон.	04.08 04.10	100
2	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	ОХУ-ын ИСБА компанийн санхүүжилтээр Дорноговь аймгийн Замын-Үүд суманд 2024.11.04-2024.10.1.05..08-ны өдрүүдэд зохион байгуулагдах рентгены сургалтад хамрагдсан.	11.04 11.08	100
3	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	Сургалтад цахим болон танхимаар оролцсон байна.	ГЕГ-ын даргын 2024.09.06-ны өдрийн А/459 дүгээр тушаалаар ОХУ-ын ИСБА компанийн санхүүжилтээр Санкт-Петербург хотноо 2024.09.27-2024.10.05-ны өдрүүдэд зохион байгуулагдах рентгены сургалтад хамрагдсан.	09.27 10.05	100
4	Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах.	Гаалийн хэргийн англи хэлний мэдлэг дээшилж, "Glossary of international trade and customs terms"-ыг судалсан байна.	Гаалийн хэргийн англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор "Glossary of international trade and customs terms"-ыг судалж байна.	01.02 06.05	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТ, БҮРДҮҮЛЭЛТИЙН ГАЗРЫН ГААЛИЙН
УЛСЫН БАЙЦААГЧ Э.ОДБАЯР



2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Э.ОДБАЯРЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР
ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Хяналт, бүрдүүлэлтийн газар

1.ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. “Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх, түүний аюулгүй байдлыг хамгаалах”-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1	Бараа, тээврийн хэрэгсэл, чингэлэгийн хяналтыг сайжруулах.	50	5	55	
2	Гаалийн хяналтын тоног төхөөрөмж, эрэлч нохойг гаалийн хяналтад үр дүнтэй ашигласан байдал.	56	6	62	
3	IRU олон улсын байгууллага болон Монголын авто тээвэрчдын нэгдсэн холбоо (НАРТАМ) –той хамтран TIR-EPD, e-TIR системүүдтэй мэдээллийг цахимаар солилцох	60	10	70	
4	Бодлогын бичиг баримтын зорилт, арга хэмжээний хэрэгжилт	55	6	61	
5	Үүрэг даалгаврын биелэлт	55	6	61	
6	Ажлын цаг ашиглалт	55	6	61	
Нэмэлт үүрэг даалгаврын биелэлт					
1	Уулзалтад оролцох	60	10	70	
2	Цахим уулзалтад оролцох	60	10	70	
3	ЧХОУНБГГ-ын үйл ажиллагааг танилцуулах	60	10	70	

4	Уулзалт зохион байгуулах	60	10	70	
5	Хуралд оролцох	60	10	70	
6	Уулзалтад оролцох	60	10	70	
7	Уулзалт хэлэлцүүлэгт оролцох	60	10	70	
8	Ажлын хэсэгт ажиллах.	60	10	70	
9	Ажлын хэсэгт ажиллах.	60	10	70	
10	Уулзалтад оролцох	60	10	70	
11	ГГХ-ын алба хаагч нарт сургалт	60	10	70	
12	Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарт хичээл заах	60	10	70	
13	Гаалийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалтад оролцогч нарт хичээл заах	60	10	70	

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Гаалийн хяналт, шалгалтын чиглэлээр сургалтад хамрагдах	100	15	
2.	Гадаад хэлний гаалийн хэргийн мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор англи хэлийг бие даан суралцах.	90	13.5	
Дундаж оноо			14.2	

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Дүн шинжилгээ хийх	6	

3.	Асуудал шийдвэрлэх	6	
4.	Хариуцлагатай байдал	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Дундаж оноо		6.6	

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт)	67.3
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	14.2
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо =		
(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		96.1

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга:

Хяналт, бүрдүүлэлтийн газрын даргын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

(Б.Даваасүрэн)

(огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:
Гаалийн улсын байцаагч

(Э.Одбаяр)

(огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

(Г.Энхтайван)

11/20, 2024 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:
Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын
ахлах байцаагч

(Ө.Тэгшээ)

2014.12.20 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга

(Р.Отгонжаргал)

(огноо)

